



ДУНГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 81

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өндөршил сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 18,000,000.00 /Арван найман сая төгрөг/-ний анхны өртөгтэй, 4,500,000.00 /Дөрвөн сая таван зуун мянган төгрөг/-ний хуримтлагдсан элэгдэлтэй 51-81 ДУА улсын дугаартай УАЗ-31512 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 3,500,000.00 /Гурван сая таван зуун мянган/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Өндөршил сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга У.Алтанхүүд даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэжид үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ



Б.ДОРЖСҮМБЭР